

УЛАМЖЛАЛТ БОЛОН ОРЧИН ЦАГИЙН АНАГААХ УХААН ДАХЬ ЯСНЫ ТООГ
ХАРЬЦУУЛАХ НЬ

Түдэвдагва Л.¹, Болд Ш.², Туул Х.², Ариунжаргал Т.², Бат-Очир М.², Базаррагчаа С.²,
Энхжин Г.², Дуутбаяр Х.²

^{1,2}Уламжлалт анагаах ухаан судлалын тэнхим, ЭЗШИУС

Email: tudevtagva@monos.mn

COMPARISON STUDY OF NUMBER OF BONES IN HUMAN BODY OF
TRADITIONAL AND MODERN MEDICINE

Tudevtagva.L,¹ Bold. Sh,² Tuul. Kh,² Ariunjargal.T,² Bat-Ochir.M,² Bazarragchaa.S,² Enkhjin.G,²
Duutbayr.Kh²

Traditional medicine research department of MUPS

Email: tudevtagva@monos.mn

Background

During the historical development of traditional medicine, many books and manuscripts have been written in Mongolian medicine. The main textbook of traditional medicine states that: “The size of a bone consists of 23 bone species, 28 spinal joints, 24 ribs, 32 teeth, and 360 pieces of bone.”

However, modern medicine estimates that the human body has 206 bones. Therefore, this topic was chosen to study the source material of traditional medicine, including the structure of the human body, and the number of bones in the modern medical anatomy textbook.

Purpose: Details of the number of bones in the human body in the “Four Medical Tantras”

(ᠰᠢᠨᠳᠤᠮᠤᠨᠠᠨᠠᠭᠤ) of traditional medicine and its commentary, as well as compare with the number of bones in the basic textbook of anatomy of modern medicine.

Objectives: In order to successfully implement the research objectives, the following objectives will be implemented. These include:

1. Sampling and analyzing number of bones from traditional medicine;
2. Sampling and analyzing bone numbers from modern medical textbooks;
3. Compare the names and numbers of bones in traditional medicine and modern medicine

Results: The number, classification and features of human bones were analyzed from the main scriptures of traditional medicine such as “Explanatory Tantra”, of the “Four Medical Tantras” and the “Legs bshad gser gyi thur ma” by Blo-bzang-chos-grags. In addition, the number of bones in the human body was sampled from modern medical textbooks and prepared for comparison. The number and characteristics of bones in the human body were compared by traditional medicine and modern medicine and made a conclusion.

This study reveals that the foundations for the integrated development of traditional medicine were laid long ago in Mongolian medicine. In addition, to highlight the book “Four Medical Tantras”, which is the basis of the textbook on the structure of the human body and the research work of scientists and scholars, which is considered in Mongolian mamba datsan’s contribution to the science of human anatomy. The importance of this research is to change the extremes of Western medicine and traditional medicine and increase opportunities to use its introduction and development into training and clinical practice

Conclusion

1. The main creature of body structure in traditional medicine is the “Four Medical Tantras” which generally assumes that the numbers of bones are 360 but does not specify it in detail. During the research, we identified 357 bone names to identify each bone. The names and locations of the three bones were not clearly marked in the medical sources.

2. The numbers of bones are 206 in modern medical textbooks. We recalculated 151 bones based on traditional medical sources without duplication of that.

3. Compared to traditional medicine and modern medicine, the number of bones and are higher than 154 bone names in traditional medicine because we included the number of teeth, small bones in the ears and small bones in the fingers and toes. Some cartilage was also counted as bones.

Key words: Number of bones in human body

Үндэслэл

Уламжлалт анагаах ухааны түүхэн хөгжлийн явцад Монголын анагаах ухаанд олон ном, судар бичигдэн үлдсэн байдаг. УАУ-ы гол сурах бичиг буюу “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т “Ясны хэмжээ нь ясны зүйл 23, нурууны үе 28, хавирга 24, шүд 32 бий, 360 хэсэг яс байна” хэмээжээ. Гэвч орчин цагийн анагаах ухаанд хүний бие нь 206 ястай гэж үзсэн байдаг.

Иймээс УАУ-ы сурвалж бичгийн судлал түүний дотроос хүний биеийн бүтэц зүйн бүтээл болон орчин цагийн анагаах ухааны анатомийн номонд буй ясны тоог харьцуулан судлахын тулд энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго: Уламжлалт анагаах ухааны шүнгийн ном түүний тайлбарт буй биеийн ясны тоог нарийвчилан гаргаж, орчин цагийн анагаах ухааны анатомийн үндсэн сурах бичгийн ясны тоотой харьцуулах.

Зорилт:

1. Уламжлалт анагаах ухааны судар номоос ясны тоог түүвэрлэн авч хүснэгтэлж, задлан шинжлэх.
2. Орчин цагийн анагаах ухааны ном сурах бичгээс ясны тоог түүвэрлэн авч хүснэгтэлж, задлан шинжлэх.
3. Уламжлалт анагаах ухаан болон орчин цагийн анагаах ухааны ясны тоог харьцуулан гаргах.

Судалгааны ажлын материал, арга зүй

Судалгааны материал

1. “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Номлолын үндэс” хэмээх оршивай. (Өмнөх үг бичиж, хэвлэлд бэтгэсэн Ш.Болд. УБ, 2018)
2. Дармо Маарамба Лувсанчойдог. “Алтан хадмал”, дээд дэвтэр, ӨМ, АХХ, 1984.
3. “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн дэвтэр”. (Өмнөх үг бичиж хэвлэлд бэлтгэсэн Б.Ренчин) УБ.1971
4. Өрнө дахины анатоми ба анагаах ухааны зохиолуудыг шүүн тунгааж харьцуулах судалгаанд ашиглав.

Судалгааны арга

1. Герменевтик арга

Герменевтик гэдэг нь тайлбарлах хөрвүүлэх гэсэн Грек үгнээс гаралтай, эртний үеийн ном судрууд, соёлын дурсгалт зүйлүүдэд утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулах зорилгоор герменевтик арга зүйг боловсруулжээ.

2. Эх бичиг, сурвалж бичгийн судлал

Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ ажлынхаа зорилго, зорилтууддаа нийцүүлэн бүтээл бичигдсэн цаг хугацаагаар хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн түүхийн судалгааг хийж улмаар гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзсэн. Түүнчлэн зохиолуудын дотор

агуулагдах уламжлалт анагаах ухааны биеийн бүтэц зүйтэй холбоотой мэдээ, сурвалжуудыг түүвэрлэн авч цаг хугацааны дараалалд оруулан өөр бусад бүтээлүүдийн мэдээллээр баяжуулан оюун дүгнэлт хийсэн.

3. Түүхэн харьцуулалтын арга

Бид уламжлалт анагаах ухааны шүнгийн ном түүний тайлбарт буй биеийн ясны тоог тогтоон улмаар орчин цагийн анагаах ухааны анатомийн үндсэн сурах бичгийн ясны тоотой харьцуулан судлахад энэхүү аргыг ашиглав.

4. Нэг төрлийн объект болох хүний биеийн бүтэц зүйн тогтолцоо онцлогийг судлах аргууд

Бидний судалгааны үндсэн объект болох хүний биеийн бүтэц зүйн талаарх орчин цагийн анагаах ухааны анатомийн судалгааны гол арга гэгддэг задлан шинжилж хэсгээс бүхлийн талаарх бүрэн мэдээлэл олж авдаг аргаар (индукц) Монголчууд эдүгээгээс олон арван жилийн тэртээ хэрэглэж ирсэн номыг мөн тэр цаг үед баримталж ирсэн Дорно дахины анагаах ухааны бие бүтэц зүйн учир шалтгаан (логик) язгуур үндсийг дээд бясалгалын арга зүйгээр туурвисан уламжлалт бүтээлүүдтэй харьцуулан жишиж чухамхүү хүний бие махбодын талаарх үзэл баримтлалын мөн чанар онол арга зүйн үндсийг тогтоож өгөв.

Үр дүн: Уламжлалт анагаах ухааны судар номонд буй ясны тоон судалгааны дүн

Яс нь хорин гурав төрөл, 360 хэсэг

Үүнээс нурууны үе хорин найм, хавирганы тоо нь хорин дөрөв, шүдний тоо нь гучин хоёр нийт 360 хэсэг яс байдаг хэмээн шүнд номложээ. Гэвч “Алтан хадмал зохиол”-д дурьдахдаа өөр номонд гавлыг 9 хэсгээр бодож 365 хэсэг болно гэжээ.

Биеийн 7 тамирын дотроос ясны хэмжээ нь яс болгоны адилгүй байдгаас шалтгаалах бөгөөд үндсээр нь хэлье.

Толгойд 5: Гавлын яс, духны яс, хамрын яс, шүдний яс, доод эрүүний яс.

Нурууны яс, түүний хажуу дахь сэрвээний яс, охор сүүлний яс, сүүжний яс, далны яс, эгэмний яс, өвчүүний яс, хавирганы яс, тэдгээрийн мөгөөрс их биед 9 буй. Харитын чөмөг, бугуй, нударганы яс луугаа гарт 3 буй. Гуяны чөмөг, тойг, хянгар шилбэ, борви, хөлийн сээр яс луугаа хөлд 5 буй.

Эдгээрийг нийлүүлсэн 22 зүйл дээр хөл, гарын хумсыг нэг зүйл болгон нийлүүлвэл 23 болно. Үүнийг хураангуй төдий хэмээн ойлго.

Ер нь 360 яс байдаг гэдгийг эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу 4 хүний хүүрийг туячиж үзсэнд том яс тохой хэртэйгээс аваад, жижиг яс хуруу хэртэйгээс дээш хүртлэхийг нарийвчлан тоолж бодоод улаан хөтөлбөрт буулгасан байгаа юм.

Эдгээрээс өчүүхэн буурцгийг хөөлгөсөн төдий жижиг яс олон гарч байсан боловч, энд тэмдэглээгүй болно. Үүнээс гадна Энэтхэг, Хятадын анагаах ухааны зохиолоос орчуулсан зарлиг, шастируудад тэмдэглэгдсэн таалал нэн гүн байх тул өөрийн оюунаар шинжилж чадсангүй.

Төвөд орны мэргэдийн зохиосон шастир олон байхыг үзсэн боловч зарим нь далд нуусан, олонх нь нарийн хянамгай бодоогүйгээс санамсаргүй хоцроосон, зарим нь нарийн бодож гаргахаар оролдсон байвч чадаагүй байна.

Гэхдээ ясны хэсэг 360 байдгийг дотор агуулгатай нийцэж байгаа бол 360 хоногт амарлингуй догшин эзэд 360 оршдогтой холбож хэлсэн байж болохыг анхаарах хэрэгтэй. Амирлангуй догшин эзэд гэдэг нь хүн насан эцэлсний дараа хойд төрлөө олход нь тусалдаг хэмээн үздэг байна.

Яс нь биеийн тулгуур хэсгүүдийн хэлбэр дүрсийг бүтээдэг. Яс нь үр хөврөлийн үед эцгийн цагаан дусал болон шороон махбодоос

үүсдэг. Идэж уусан идээний болон өөхний тамирын тунгалгаас төлждөг. Ном сударт араг ясыг бүрдүүлж буй ясны тоог 280-365 гэж харилцан адилгүй тэмдэглэжээ.

Өрнийн анагаах ухааны анатомийн сурах бичгээс уламжлалт анагаахын ястай дүйцэх тоог түүвэрлэн шинжилсэн дүн

Ясны ангилал

Толгойн яс: Толгойн ясыг дотор нь гавал ба нүүрний гэж ангилдаг.

Гавлын яс нь чамархайн хос, дагз, дух зулайн хос, тархины суурь яс, сонсголын гурван яснуудаас бүрдэнэ. Тархины яс хоорондоо хөдөлгөөнгүй холбогдсон 8 ширхэг хавтгай яс байдаг.

Нүүрний яс нь хацар, хамар, самалдаг, эрүүний (дээд, доод) нулимсны, тагнайн, хэлний угийн яснуудаас бүрдэнэ. Эдгээрээс доод эрүү хөдөлгөөнтэй бусад яс нь хөдөлгөөнгүйгээр хоорондоо холбогддог.

Их биеийн яс: Их биеийн ясыг багана нурууны, цээжний хэнгэрцгийн гэж ангилна.

Хүний багана нуруу нь 33-34 нугалмаас тогтож, хоорондоо мөгөөрсөөр холбогдох тул чөлөөтэй хөдөлнө.

- Дотор нь: Хүзүүний -7
- Цээжний -12

Бүсэлхийн-5

Ууцны-5

Ахар сүүлний-5 гэж ангилна.

Цээжний 12 нугалмаас 12 хос хавирга гарч цээжний өмнөд талд 7 нь өвчүүтэй шууд 5 нь хоорондоо мөгөөрсөөр холбогдож, өвчүүтэй нийлнэ. Дээрээс доош дарах дараалттай холбоотой сээр нурууны нугалмуудын хэмжээ доошлох тусам томордог.

Дээд мөч: Мөрний бүслүүр гарын яснуудаас бүрдэнэ. Мөрний бүслүүр ясны эгэм, дал орно. Эгэм, далыг цээжтэй холбодог товчлуур яс юм. Гарын яс нь бугалга, шуу, сарвууны яснаас бүрдэнэ. Шууны яс зэргэлдээ орших тохойн яс, цацраг яснаас тогтоно. Сарвууны яс шууны ястай 2 эгнээ 8 жижиг бугуйн ясаар холбогдоно. Алганы 5 богино чөмөгт яс, хурууны 14 богино (эрхий хуруу 2 үетэй бусад нь 3 үетэй) чөмөгт яснаас тогтоно.

Доод мөч: Аарцагны бүслүүр ба хөлний яснуудаас тогтоно. Аарцагны бүслүүр яс нь хос сүүж яснаас тогтох бөгөөд араараа ууцтай, өмнө талаараа өөр хоорондоо нягт холбогдоно. Хөлний яс дунд чөмөг, шилбэ болон тавхайн яснуудаас бүрдэнэ. Шилбэний яс нь шаант ба тахилзуур яснаас, тавхайн яс өсгий хоёр эгнээ 7 яс, өлмий 5 богино, хурууны 5 чөмөгт яснаас тус тус тогтоно.

Table 1.

The determine of number of bones in human body of Traditional and modern medicine

The medical works of researchers	All number of bones	Head bones	Chest bones	Arm bones	Leg bones
“Four Medical Tantras” (XII century)	360	100	120	70	70
A.Vezalis De Humani Corporis Fabrica Libri Septem (On the structure of the human body)” 1543	307	60	63	100	84
“ДТДТБББ” 1679	251	60	69	62	60

M.G.Prives "Human anatomy" 1974	216	29	59	64	64
Study of Dagdanbazar.B 2002	226	31	59	68	68

Бид судалгааны явцад “Анагаах ухааны дөрвөн үндэс”, түүний тайлбар “Алтан хадмал” сударт тэмдэглэгдсэн, Орчин цагийн анагаах ухааны сурах бичигт тэмдэглэгдээгүй 151 ясыг тодруулан гаргав. Үүнд:

Шүд-32

Шүдний уг- 32

(Эрүүл хүний шүд 40 байж болно)

Илүү шүд-8

Уг нь-8

Аюулхайн яс-1

Өвчүүний хуруу яс-12

Хавирганы мөгөөрс-24

Хумс-20

Чихний мөгөөрс яс-2

Шилний ар мөгөөрс яс-8

Нүдний яс-4

Бүгд 151 ясыг тогтоосон.

Дүгнэлт

1. Уламжлалт анагаах ухааны биеийн бүтцийн тухай гол бүтээл “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т ясны тоог 360 байдаг хэмээн ерөнхийлөн үздэг ч нарийвчлан тооцоогүй байдаг. Бид судалгааны явцад яс нэг бүрийг тогтоохоор ажиллаж 357 ясны нэрийг тооцон гаргалаа. Гурван ясны нэр, байршил тайлбар зохиолуудад тодорхой тэмдэглэгдээгүй байв.

2. Орчин цагийн анагаах ухааны ном сурах бичигт ясны тоог 206 гэдэг. Бид үүн дээр давхардуулалгүйгээр уламжлалт анагаах ухааны сурвалж бичигт тулгуурлан 151 ясыг шинээр тооцон гаргав.

3. Уламжлалт анагаах ухаан болон орчин цагийн анагаах ухааны ясны тоог харьцуулахад уламжлалтын хувьд ясны тоо 154-өөр илүү байгаа нь шүдний тоо, чихний жижиг ясны тоо, гар, хөлийн хурууны жижиг ясны тоог нарийвчлан тоолсонтой холбоотой. Түүнчлэн зарим мөгөөрсийг яс хэмээн тоолсон байна.

Хэлцэмж:

Бид судалгааны явцад хүний биеийн бүтцийн талаарх анхны ойлголтыг Египетчүүд занданшуулга “муми” хийх дадлагаасаа олж авсан хэмээн үзэж байна. Гэхдээ эртний монголчууд ялангуяа Хятан нар хүний цогцсыг занданшуулах аргыг өргөн хэрэглэж байсан нь бидний өвөг дээдэс энэ талаар ихээхэн мэдлэгтэй байсны баримт юм. Тухайлбал: 1981 онд БНХАУ-ын Өвөр Монголын Улаан Цав аймгийн Цахар баруун гарын Өмнөд хошууны хуучин балгаст илрүүлсэн Ляо улсын үеийн булшнаас эмэгтэй хүний цогцос олдсон байна. Үүнийг эрдэмтэд судлаач Ляо улсын сүүлч үеийн булш болохыг нотолжээ. Хэдийгээр эмэгтэйн цул, сав нь ялзран хайлсан боловч араг яс нь бүрэн бүтэн, цусны зарим эс хийгээд цөөхөн тооны цавуулаг ширхэглэг эд нь үлдэн хоцорсон байна. Хүний биеийн араг ясыг бүрдүүлж буй нийт ясны тоо судлаач бүрийнхээр харилцан өөр байгаа нь судалгааны түвшин, он цаг, танин мэдэхүй үе шат бүхэнтэй уялдаатай байгаа нь харагдаж байлаа. Бидний судалгаанаас харахад нэлээд эрт үеэс орчин үеийг хүртэл судлаачид өөр өөрийн үзэл баримтлалын дагуу ясны тоо, нэршлийг тогтоож ирсэн нь тодорхой харагдаж байлаа. Гэхдээ тухайн цаг үеийн шинжлэх ухааны ерөнхий түвшин эд, эс судлалын шинжилгээний хөгжилтэй уялдан ясны эдийн бүтцийн онцлогийг таньж ялган тогтоох байдлаар нарийвчилсан судалгааны дүнд жинхэнэ бүтцийн онцлогийг харгалзан ясыг тодорхойлон тоог тогтоох нэршлийг оновчтой оноох явдал зүй

ёсоор хийгдэж ирсэн болох нь нотлогдож байна.

Ном зүй

1. Анагаах ухааны дөрвөн үндэс. Хөх хот, ӨМАХХ, 1986.
2. Анагаах ухааны язгуурын үндэсийн бүрэн тайлбар. Хөх хот ӨМАХХ, 1989.
3. Анагаах ухааны дөрвөн үндэс /Язгуурын үндэс ба Номлолын үндэс. (Төвөд, Монгол, Англи, Орос хэлээр) УБ, 2001.
4. “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Номлолын үндэс” хэмээх оршивай. (Өмнөх үг бичиж, хэвлэлд бэтгэсэн Ш.Болд. УБ, 2018) ном,
5. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2005, х125-460
6. Дагданбазар Б. Орчин үеийн биеийн бүтэцзүй судлалын хөгжилд монголын эмч, зодч нарын бүтээлийн үүргийг тодорхойлох асуудалд, Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2002.
7. Дарму Мааранба Лувсанчойдог. Алтан хадмал, дээд дэвтэр, ӨМАХХ, 1984.
8. Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн дэвтэр. УБ. 1971.
9. А.Везалий “О строений человеческого тела” 1534 г
10. М.Г. Привес “Анатомия человека” 1974 г

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Л.Лхагва*